



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/344

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Жаргалант, Буянт сумдад 2018 онд гарсан малын гоц халдварт боом өвчний үед хяналтын постонд ашигласан 15 ширхэг эсгий худалдан авах 2 039 00 төгрөг, мөн хүчтэй шороон шуурганы улмаас аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн унасан хашаа, өвсний саравчны дээвэр засварлахад шаардлагатай 2 952 550 төгрөг нийт 4 991 550 төгрөг, Covid-19 халдварт цар тахал өвчний сэжигтэй тохиолдлоор 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Цамбагарав зочид буудалд тусгаарлагдсан иргэдийн хоол, байрны зардал 2 180 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 7 171 550 төгрөг /Долоон сая нэг зуун далан нэгэн мянга таван зуун тавин/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 61497